



ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

2026 оны 06 дугаар сарын 29

Аудитын харилцан хамаарал:

Төрийн сангийн тогтолцоо нь улс, орон нутгийн төсвийн мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, хуваарилах, үр ашигтай захиран зарцуулах, төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэхэд чухал ач холбогдолтой салбар мөн.

Төрийн сангийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлснээр төсвийн ил тод, хариуцлагатай байдал дээшилж, орон нутгийн эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх үндсэн зорилготой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч болон холбогдох төрийн байгууллагууд төрийн сангийн өдөр тутмын үйл ажиллагаанд засаглах эрхтэй оролцохдоо зохистой удирдлагыг хэрэгжүүлж, үр нөлөөтэй дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх ёстой. Ингэснээр төсвийн хөрөнгийн үр өгөөж нэмэгдэж, санхүүгийн сахилга бат бэхжих юм.

Төрийн аудитын байгууллаас өмнөх жилүүдэд Төрийн сангийн үйл ажиллагаа, төсвийн байгууллагуудын эрхэлж байгаа үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хүрээнд нийцэж байгаа эсэх, санхүүгийн сахилга бат хэрхэн хангагдаж байгаад тогтмол хяналт тавьж ирсэн. Төрийн сангийн засаглал, сайн туршлагыг идэвхтэй сайжруулах арга хэмжээ авч эхэлсэн ч хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод хяналтын сул талууд байсаар байна.

Аудитын зорилго ба хамрах хүрээ:

Аудитын зорилго нь Завхан аймгийн Төрийн сангийн тогтолцоо орон нутгийн түвшинд оновчтой бүрдсэн эсэх, санхүүгийн үйл ажиллагаа болон төлбөр тооцоог холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хэрэгжүүлж буй эсэхэд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан Завхан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, Үндэсний аудитын газарт хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд оршино.

Аудитын гол асуудал:

1. Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх;
2. Төрийн сангийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх;

Аудитад хамрагдсан байгууллага:

Аудитын хамарсан хүрээний дагуу Завхан аймгийн хэмжээнд Төрийн сангийн удирдлагын цахим систем болон Төрийн албаны цалингийн нэгдсэн системийг ашиглаж буй дараах байгууллагуудыг хамруулав. Үүнд:

- Завхан аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс

- Сумуудын Санхүүгийн алба буюу 24 сумын төрийн сан
- Эрхийн бүртгэлийн болон Төрийн сангийн удирдлагын цахим системд бүртгэлтэй төсвийн байгууллагууд
- Төрийн албаны цалингийн нэгдсэн системд хамрагдсан байгууллагууд

Аудитын хязгаарлалт:

- ❖ Аудитын явцад хэрэгжүүлсэн санхүү, үйл ажиллагааны үзүүлэлтүүдийн дүн шинжилгээ нь Завхан аймгийн хэмжээн дэх нийт 25 төрийн сан буюу Санхүү, төрийн сангийн хэлтэс болон 24 сумын Санхүүгийн алба хамаарах бөгөөд төрийн сан тус бүрийн дотоод зохион байгуулалтын нарийвчилсан онцлог, систем ашиглалтын өдөр тутмын бүх үйлдлийг тус бүрээр нь нэг бүрчлэн үнэлэх боломжгүй тул, түүвэрлэсэн үзүүлэлт болон ТСУЦС-ийн нэгдсэн өгөгдөлд тулгуурласан болно.
- ❖ Мөн тодорхой үүрэг хариуцлагын хуваарилалт, дотоод хяналтын нарийвчилсан эрсдэлийг төсвийн 307 байгууллага тус бүрийн түвшинд гүнзгийрүүлэн үзээгүй бөгөөд аймгийн хэмжээний нэгдсэн чиг хандлага, түгээмэл илрэлтэй зөрчилд үндэслэсэн.

Аудитын гол үр дүн:

1. ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО БОДЛОГО, ЧИГ ҮҮРГИЙГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

- **Эрх зүйн актын нийцэл:** Төсвийн ерөнхийлөн захирагчийн гаргасан төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн акт нь холбогдох хууль тогтоомжтой нийцэж байна. Шалгалтаар ТЕЗ нь Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой "Дотоод хяналт хийх төлөвлөгөө"-г баталсан Аймгийн Засаг даргын 2023 оны А/48, 2024 оны А/44, 2025 оны А/33 тоот захирамжуудаас өөр шийдвэр гаргаагүй бөгөөд энэ нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.9.5 дугаар заалттай нийцжээ.
- **Хараат бус байдал алдагдсан эрсдэл:** Аймаг, сумын төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчид тухайн шатны Засаг даргын Тамгын газарт харьяалагдаж байгаа нь төрийн сангийн бодлого, үйл ажиллагааг хууль эрх зүйд нийцүүлэн бие даан, хараат бусаар явуулж чадахгүй байх эрсдэлийг дагуулж байна.
- **Орон тооны дутагдал ба хавсран гүйцэтгэл:** Аймгийн түвшинд салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн дарга нь Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргыг хавсран гүйцэтгэж, орлого хариуцсан мэргэжилтний орон тоог эзэнгүй орхисон байна. Сумдын түвшинд Засгийн газрын 326 дугаар тогтоолоор 5 орон тоотой байхаар баталсан ч амьдрал дээр 2 орон тоотойгоор ажиллаж байгаа бөгөөд Улиастай, Тосонцэнгэл, Цагаанчулуут, Тэлмэн зэрэг сумуудад санхүүгийн албаны дарга болон мэргэжилтний үүргийг хавсран гүйцэтгэж байна.
- **Чиг үүргийн давхардал ба тусгагдаагүй заалтууд:** Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавартай харьцуулахад сумдын санхүүгийн албаны дарга болон мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод хэд хэдэн чухал чиг үүрэг тусгагдаагүй байна. Мөн *төсвийн орлого татварын төлөвлөлт, төрийн сангийн гүйцэтгэл хяналт, тайлан мэдээ нэгтгэх, мэргэжил арга зүй, дотоод аудит* зэрэг албан тушаалын гүйцэтгэх 5 чиг үүрэг хоорондоо шууд давхардаж байна.
- **Ажлын байрны тодорхойлолтоос гадуурх ачаалал:** Санал асуулгаар 54 албан хаагчийн 15 нь ажлын байрны тодорхойлолт нийцдэггүй гэсэн бол, 46 албан хаагч (85.1%) ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй өөр чиг үүрэг буюу худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд ажиллах, Shilen.gov.mn-д мэдээлэл оруулах, иргэдийн хувьцааны данс нээх, статистик тооллого хийх гэх

мэт ажлуудыг гүйцэтгэж, ажлын ачааллыг зохиомол олноор нэмэгдүүлж байна. Энэ нь төлбөр тооцоог хянаж батлах үндсэн үүрэгт ашиг сонирхлын зөрчил үүсгэх эрсдэлтэй байна.

- **Цахим системийн ашиглалт ба шинэчлэл:** Төрийн сангийн цахим системийн бүтэц хэрэглэгчийн хэрэгцээг 98 хувь хангаж, шуурхай ажиллах боломж олгож байгаа ч интернэтийн саатал, цахилгааны тогтворгүй байдал, оргил үеийн серверийн гацалт хүндрэл үүсгэж байна. Системийг улам төгс болгохын тулд Шилэн дансны системтэй шууд автомат холболт хийх, хэрэглэгчийн нэрийг домэйн хэлбэрт шилжүүлж аюулгүй байдлыг чангатгах шаардлагатай байна.

2. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨДӨР ТУТМЫН ХЯНАЛТ СУЛ БАЙГААГААС ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

- **Санхүүжилтийн эрх хугацаа хоцордог шалтгаан:** Санхүүжилтийн эрхийг сар бүрийн ажлын эхний 5 хоногт багтаан олгох журамтай ч Сангийн яамнаас аймагт хуваарилах орлого сар бүрийн 5-8-ны өдрүүдэд орж ирдэг тул сумдын санхүүжилтийн эрхийг сар бүрийн 10-наас хойш хоцроож нээж байна. Нийт 690 байгууллагын батлагдсан төсвийн хуваарийг дансны хуулгатай тулгахад батлагдсан төсвөөс 4,027.7 сая төгрөгөөр илүү, 15,503.2 сая төгрөгөөр дутуу олгосон зөрчил илэрсэн.
- **Дансны зарцуулалтын эрх нээх үеийн журмын зөрчлүүд:**
 - **Нэмэлт санхүүжилт:** Түүвэрлэн шалгасан 799 байгууллагын нэмэлт санхүүжилтийн эрх нээх хүсэлтээс хуульд заасан үндэслэл бүхий шийдвэр, баримтуудыг хавсаргаагүй, зөвхөн албан тоотоор эрх нээсэн 92 байгууллагын 984.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн.
 - **Барьцаа хөрөнгө:** Барьцааг чөлөөлөх хугацаа болоогүй байхад эрх нээж барьцаа хөрөнгийг чөлөөлсөн, урсгал зардлын гүйлгээний эрх нээсэн 685.5 сая төгрөгийн 14 гүйлгээний зөрчил илэрсэн.
 - **Захиалагчийн хяналтын зардал:** Журамд заасан техник хяналтын зардлыг зориулалтаас гадуур, зориулалт бус зардалд зарцуулалтын эрх олгосон 86 гүйлгээний 982.2 сая төгрөгийн зөрчил тус тус илэрлээ.
- **Үлдэгдлийн баталгаажуулалт тогтмолжоогүй:** Аймаг, сумдын төрийн сан дансны үлдэгдлээ тулгадаг ч судалгаанд хамрагдсан сумдын 20 хувь буюу 4 сум нь хагас жил тутмын тооцооны үлдэгдлийн баталгаажуулалтыг огт үйлддэггүй гэж хариулсан байна.
- **Анхан шатны баримт дутуу гүйлгээнүүд:** Төрийн сангийн өдөр тутмын хяналт сул байгаагаас 50.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээнүүдийг шалгахад: Төлбөрийн мэдэгдэлд эрх бүхий албан тушаалтны гарын үсэггүй, ажил гүйцэтгэх болон халаалтын гэрээ хавсаргаагүй, ИТХ-ын тогтоолгүй гүйлгээг баталгаажуулсан 3,556.0 сая төгрөгийн 26 зөрчил илэрлээ. (Тухайлбал: "Манант оргил" ХХК-ийн 54.9 сая, "Би би Ди Эм" ХХК-ийн 170.5 сая, Борх ямаан ус ХХК-ийн 100.0 сая төгрөгийн гүйлгээнүүд гарын үсэггүй батлагдсан).
- **Төсвийн жилийн хаалтын хугацаа зөрчсөн байдал:** Төв төрийн сангаас зарлагын гүйлгээг хянах, баталгаажуулах эрхийг хаах тодорхой хугацаатай чиглэл өгсөн боловч хэрэгжүүлээгүй. Эрх хаагдсан хугацаанаас хойш Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.5.8-ийг зөрчин илгээгдсэн гүйлгээний тоо эрс өсөж, 2024 онд 122.0 сая төгрөгийн 64 гүйлгээ, 2025 онд 1,966.3 сая төгрөгийн 461 гүйлгээг тус тус хугацаа хэтрүүлэн шилжүүлсэн зөрчлүүд илэрлээ.

Зөвлөмж болгосон асуудлууд:

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст:

1. **Санхүүжилтийн эрх нээх хяналтыг чангатгах:** Нэмэлт төсвийн санхүүжилт олгохдоо Төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий шийдвэр, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хянаж үзсэний үндсэн дээр зарцуулах эрхийг нээж хэвших;
2. **Зориулалт бус гүйлгээг таслан зогсоох:** Техник хяналтын (захиалагчийн хяналт) болон барьцаа хөрөнгийн дансны зарцуулах эрхийг нээхдээ журмын заалтыг чанд мөрдөж, зориулалт бус зардалд ашиглахгүй байх, мөн барьцаа хөрөнгийг чөлөөлөх хугацаа болоогүй байхад эрх нээх зөрчлийг дахин гаргахгүй байх;
3. **Хугацааны удирдлага, урьдчилсан баталгаажуулалтыг хангах:** Сар бүрийн эцсийн ажлын өдрийн гүйлгээ болон төсвийн жилийн хаалтын хугацаатай холбоотой удирдамж, чиглэлийг төсвийн байгууллагууд болон аймаг, сумдын төрийн сангуудад урьдчилан хүргүүлж, хэтрэлт үүсэхээс сэргийлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавих;
4. **Ангилал зөрчихгүй байх:** Хүн амын орлогын албан татварын (ХХОАТ) буцаан олголтын гүйлгээг хийхдээ зардлын эдийн засгийн ангиллын дагуу тухайн зориулалтын кодоор үнэн зөв шилжүүлж байх;
5. **Дотоод хяналтын ажлыг эрчимжүүлэх:** Төрийн сангийн төлөвлөгөөт хяналт шалгалтаар урьд нь өгсөн зөвлөмжүүдийн биелэлтийг эргэх холбоотойгоор тухай бүр тооцож, үр дүнг үнэлж ажиллах;
6. **Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх:** Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй дотоод болон гадаад эрсдэлийг журамд заасны дагуу тусгайлан баталсан Маягт-4, 5, 6-аар тогтмол үнэлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг хэвшүүлэх;

Аймаг, Сумдын Төрийн сангийн хянах эрх бүхий албан тушаалтнуудад:

1. **Цахим систем дэх анхан шатны баримтын хяналтыг сайжруулах:** Төрийн сангийн удирдлагын цахим системд бүртгэгдэж буй зарлага, төрийн сангийн бүртгэлийн дансны тодорхойгүй орлого, залруулга, буцаалтын гүйлгээнүүдэд эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, гэрээ, тогтоол шийдвэр зэрэг анхан шатны баримт бүрэн хавсаргагдсан эсэхийг цахим хэлбэрээр чанд хянаж, системд баталгаажуулах;
2. **Өдөр тутмын дотоод хяналтыг тогтмолжуулах:** Төрийн сангийн өдөр тутмын үйл ажиллагаа, төлбөр тооцооны гүйцэтгэлд аймаг, сумдын хянах эрх бүхий албан тушаалтнууд хуулиар хүлээсэн үүргээ чанарын өндөр түвшинд хэрэгжүүлж, үлдэгдлийн баталгаажуулалтыг тогтоосон хугацаанд хууль журмын дагуу үйлдэж хэвших;